



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 0/129

Улаанбаатар хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 6.1, “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”-ын 5.1.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын байр, талбайн түрээсийн гэрээ дүгнэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах, “Худалдаа үйлчилгээ, соёл урлаг, биеийн тамир спортын үйл ажиллагааг зохион байгуулах Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах журам” боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга	Д.Рэнцэнбямба	Орлогч дарга
Гишүүд	М.Мандах	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга
	Б.Ганцоож	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн хуулийн мэргэжилтэн
	Б.Адъяа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Уянга	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Захиргаа, санхүү, маркетингийн хэлтсийн дарга
	Б.Алтансүх	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын гэрээний мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Ж.Сувданзаяа	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

115050000341

2. Түрээсийн гэрээ дүгнэх, түрээслэгчийг сонгон шалгаруулахыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.

ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ